

# МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

**Хөгжлийн төлөөх түншлэл:  
“Төр, иргэний нийгмийн  
түншлэлийг бэхжүүлье”  
иргэний нийгмийн чуулганы ажиглалт**

**Дүгнэлт боловсруулсан  
Судлаач Ц.Батсугар**

Улаанбаатар хот  
2026 он

Холбоо барих мэдээлэл:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 43-р хороо,  
Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж,  
Юу Би тауэр, 10-р давхар, #1004

Утас: (976) 7000 0180

И-мэйл: [info@mediacouncil.mn](mailto:info@mediacouncil.mn)

Вэбсайт: [www.mediacouncil.mn](http://www.mediacouncil.mn)

## ХАРИУЦЛАГА, ЭВ НЭГДЭЛД ТУЛГУУРЛАСАН ИРГЭНИЙ НИЙГМИЙН СӨРӨН ТЭСВЭРЛЭХ ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ:

### ИРГЭНИЙ НИЙГМИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Өдгөө Монголын иргэний нийгэм томоохон сорилтуудтай нүүр тулаад байна. CIVICUS-ийн иргэний орон зайн үнэлгээ (CIVICUS Monitor)-ээр Монгол улс 59 оноотойгоор саадтай гэсэн ангилалд байгаа бол Ардчиллын Олон янз байдлын индекс (V-Dem)-ээр манай улсын иргэний нийгмийн суурь индекс 2024 онд 0,69 оноотой үнэлэгдсэн нь 2018 оноос хойш тасралтгүй буурч байгаа үзүүлэлт юм.

Монголын иргэний нийгмийн суурь индекс



Эх сурвалж: V-Institute Dem

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1948 оны 12 дугаар сарын 10-ны хурлаар Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактыг тус тус баталснаар олон улсын иргэний эрх, эрх чөлөөний суурь тавигдсан. Улмаар 1992 нь Монгол Улсын шинэ үндсэн хууль батлагдаж үндсэн эрх, эрх чөлөө түүн дотроо иргэний эрх, эрх чөлөөг тунхагласан. Иргэд энэхүү иргэний үндсэн эрх, эрх чөлөөгөө чөлөөтэй, үр дүнтэй, мөн аливаа хязгаарлалт, ялгаваргүйгээр хэрэгжүүлэх боломжийг хангасан нөхцөл, нийгмийн болон эрх зүйн хэм хэмжээний нийлбэрийг иргэний орон зай гэж ойлгодог. Ингэхдээ иргэд эрхээ бие даан эсвэл албан бус, албан ёсны зохион байгуулалттай бүлгээр хэрэгжүүлэхээс үл хамааран адил нөхцөл боломжоор хангагдах ёстой байдаг. (Malena, 2015) Эдгээр цогц нөхцөл гэдэгт

хууль эрх зүйн орчин, төрийн бодлого, институцийн орчин болон практик боломж нөхцлийг хамруулан ойлгоно. (OECD, 2022)

Нээлттэй иргэний орон зай болон чадамжит иргэний нийгэм нь хүний эрхийг эрхэмлэсэн, ардчилсан тогтолцооны үндсэн багануудын нэг юм. Иргэний орон зайн нээлттэй, ээлтэй байх нь хүчтэй иргэний нийгэм төлөвшин хөгжих үндэс суурь болж, хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах нэг үндсэн хүчин зүйл болдог. (Buuse, 2018)

Иргэний нийгэм энэхүү оролцоо, чиг үүргээ утга учиртай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тодорхой суурь нөхцөлүүд хангагдсан байх шаардлагатай бөгөөд эдгээр нь бүрдээгүйгээс иргэний орон зай хумигддаг. Эдгээр нөхцлийг ерөнхийд нь **эрх чөлөө, бодлого эрх зүйн орчин, институцийн орчин болон иргэний нийгмийн чадавх** гэсэн үндсэн бүрэлдэхүүнд ангилж болно.

Монголын иргэний орон зай хумигдахад олон тулгамдсан асуудал нөлөөлөхийн сацуу иргэний орон зайн үндсэн бүрэлдэхүүн хэсэг тус бүр сорилттой тулгарч байна. Үүнд:

- **Иргэний үндсэн эрх чөлөө** – иргэний орон зайд иргэд чөлөөтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулах үндэс суурь нь иргэдийн үндсэн эрх чөлөө хангагдсан байх явдал юм. Үндсэн эрх чөлөө гэдэгт үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тайван замаар хуран цуглах эрх чөлөө, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрх чөлөө зэргийг голчлон оруулдаг ч эдгээрээс гадна бусад эрх, эрх чөлөөг хамруулан авч үздэг. Манай улсын хувьд дээрх гурван үндсэн эрх чөлөөний үзүүлэлтийг л авч үзэхэд иргэний орон зайн хумигдсаар байна. Тухайлбал, 2020-2024 онд буюу сүүлийн 5 жилд үзэл

бодлоо илэрхийлэх эрхийн индекс 0,87-оос буурч 0,7, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхийн индекс 0,84-өөс буурч 0,65 болсон байна.

- **Хууль, эрх зүйн орчин** – нээлттэй иргэний орон зайд бүрдүүлэхэд иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн бодлого, эрх зүйн орчин чухал үүрэгтэй. 2021 онд Иргэний нийгмийн консорциум (цаашид ИНК гэх)-аас хийсэн судалгаагаар ТББ-ууд иргэний нийгмийн хууль эрх зүйн орчныг 2,52 буюу хангалтгүй гэж үнэлсэн нь нээлттэй тэгш иргэний орон зайд дэмжих хууль, эрх зүй, бодлогын орчин хангалттай бүрдээгүйг илтгэсэн үзүүлэлт юм. Тухайлбал, ТББ-ын төрөл, хэлбэр, бүртгэл, үйл ажиллагаа, тайлагналын зохицуулалт бэрхшээлтэй, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, дэмжлэгийн бодлого байхгүй, төр-иргэний нийгмийн түншлэл, харилцааны стратеги байхгүй, ТББ-ын хууль ёсны эрх ашгийг хамгаалах тогтолцоо, эрх зүйн орчин сул зэрэг нь хууль эрх зүйн орчны гол дутагдал болж байна.

1997 онд УИХ-аас Төрийн бус байгууллагын тухай хуулийг баталснаас хойш нийт 9 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Эдгээр өөрчлөлтийн ихэнх нь иргэний нийгмийн салбарын бодлогыг бие даан, цогцоор нь шинэчилсэн шинжтэй бус, харин бусад салбарын хууль тогтоомж шинэчлэгдсэнтэй уялдуулан холбогдох зохицуулалтыг нийцүүлэх зорилгоор хийгдсэн байна. Тухайлбал 1998 онд Татварын ерөнхий хууль, 2002 онд Иргэний хуулийн шинэчилсэн найруулга,

2003 болон 2015 онд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, 2016 онд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2020 онд Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2021 онд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, 2024 онд Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотой нэмэлт өөрчлөлтүүдийг тус тус оруулжээ. “Өөрчлөлтийн дуу хоолой”<sup>1</sup> төслөөс анх удаа ТББ-ын хэрэгжилтийн үр дагаварт хөндлөнгийн үнэлгээ хийж, урьдчилсан үр дүнг 2026 оны Иргэний нийгмийн чуулганд танилцуулсан нь иргэний орон зайн хууль эрх зүйн орчинд тулгамдаж буй асуудлыг тодорхойлоход чухал алхам болов.

- **Институцийн орчин** – иргэний орон зай бодитоор бүрэлдэхэд иргэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааг дэмжсэн институцийн орчин өндөр ач холбогдолтой. Ялангуяа төрийн ил тод, хариуцлагатай байдал, хууль дээдлэх ёсны хэрэгжилт зэрэг нь иргэдийн эрх чөлөөний баталгааг хангах, иргэний орон зайг дэмжихэд нэн чухал. Харамсалтай нь Монгол Улс дахь иргэний нийгмийн институцийн орчин өнөөг хүртэл асуудалтай байсаар

<sup>1</sup> Хэвлэл мэдээллийн зөвлөл, Дойче Веллэ Академи хамтран хэрэгжүүлж буй “Өөрчлөлтийн дуу хоолой: ИНБ-ууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтыг бэхжүүлэхийн төлөө хүчээ нэгтгэх нь” төсөл, Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр 2023-2026 онд хэрэгжиж байна.

байгаа нь иргэний орон зайд бэрхшээл дагуулсаар байна. V-Dem хүрээлэнгийн тооцооллоор 2024 оны дүнгээр манай улсад төрийн эгэх хариуцлагын индекс 0,77; иргэдийн оролцооны индекс 0,57; хууль дээдлэх ёсны индекс 0,53 байна. Энэ мэт засаглал, институцийн асуудал нь иргэний орон зайд дарамт үүсгэж байна. Тухайлбал, ИНК-аас явуулсан 2021 оны судалгаагаар ТББ-уудын 41,7 хувь нь төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс аливаа төрлийн дарамт шахалтад өртсөн; 17,6% нь хууль дээдлэх ёс, хүний эрх хамгаалсны төлөө аливаа саад бэрхшээлтэй тулгардаг гэсэн бол ТББ-ын 49,8% нь төрийн хүнд суртал үйл ажиллагаа явуулахад бэрхшээл болдог гэв.

**Иргэний нийгмийн чадавх** – Монгол Улсад чөлөөт иргэний нийгэм төлөвшөөд удаагүй байна. Энэ утгаараа монголын иргэний нийгмийн чадавх хэврэг хэвээр байна. УБЕГ-ын мэдээгээр 31,518 ТББ бүртгэлтэй боловч багагүй хувь нь үйл ажиллагаа явуулахгүй байна. Тухайлбал, 2023 онд 6636 ТББ-ыг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу 8 болон түүнээс дээш улирал дараалан санхүүгийн тайлан гаргаагүй гэсэн үндэслэлээр улсын бүртгэлээс хассан. ИНК-ын судалгаанд оролцсон<sup>2</sup> ТББ-ын 18% нь үйл ажиллагаа тасалдаж байсан гэсэн нь ИНБ-ууд тогтвортой үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байгааг илтгэдэг. Энэ нь иргэний **НИЙГМИЙН** хүний нөөцийн

<sup>2</sup> О.Саранчулуун, Ц.Батсугар. (2021). Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчныг бий болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа. Иргэний Нийгмийн Консорциум. Улаанбаатар.

чадавх сул (70,4% нь 5 хүрэхгүй ажилтантай), санхүүгийн нөөцийн хүрэлцээгүй байдал (79,6% нь эрсдэлээс сэргийлэх санхүүгийн нөөц, чадавхгүй) зэрэг бэрхшээлээс үүдэлтэй байна. Түүнчлэн, иргэний нийгмийн салбарт өнөөг хүртэл хамтын удирдлага, хариуцлага, хамгааллын тогтолцоо бүрдээгүй байгаа нь ИНБ-ууд иргэний орон зайн цаашдын хямрал, төрийн дарамт, эрх зүйн орчны доройтол, хууль ёсны эрх ашиг зөрчигдөх, салбарын санхүүгийн болон эдийн засгийн эрсдэл зэрэгт өртөмтгий хэвээр байна.

Эдгээр чиг хандлагыг нийтэд нь авч үзвэл нээлттэй, шударга, хүртээмжтэй иргэний орон зай бүхий л талбарт хумигдах хандлагатай байна. Энэ нь бүрэн төлөвшиж бэхжээгүй иргэний нийгмийн салбарт олон эрсдэл дагуулж, улмаар иргэний нийгмийн салбар уналтад орох бодит аюул үүсээд байна.

### Иргэний нийгмийн тулгамдсан асуудал

Салбарын суурь асуудал, тогтолцооны бэрхшээл, шинэ тутам чиг хандлагууд нь иргэний нийгмийн салбарт харилцан уялдаатай олон тулгамдсан асуудлыг дагуулж байна. Гэвч сүүлийн жилүүдэд өрнөсөн иргэний нийгмийн хэлэлцүүлгүүдэд бодлого, эрх зүйн орчны асуудал голлох байр суурь эзэлсээр ирсэн. Энэ нь 2021 оноос ТББ-уудын үйл ажиллагаанд эрсдэл дагуулах хуулийн шинэчлэлийн санаачлагууд идэвхтэй хэрэгжсэнтэй холбоотой. Тухайлбал, холбоо болон сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүд, мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль зэргийг дурдаж болно.

Иймд, иргэний орон зайг бэхжүүлэхэд нэн тэргүүнд ТББ-ын тухай хууль, эрх

зүйн зохицуулалтын асуудал хөндөгдөнө. Учир нь ТББ-ууд нь иргэний нийгмийн салшгүй нэг хэсэг төдийгүй цөм болсон томоохон хэсэг нь юм. Эрх зүйн орчны тулгамдсан асуудалд дараах асуудлууд тогтмол дурдагддаг. Үүнд:

- **Хуулийн нэр томъёо зөрүүтэй байдал** – Иргэний Нийгмийн Чуулганд танилцуулсан ТББ-ын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд<sup>3</sup> дурдсанаар ТББ-ын үйл ажиллагааг зохицуулсан 514 хуулийн зохицуулалт байгаа ч эдгээрт хэрэглэсэн нэр томъёо харилцан зөрүүтэй байна. Тухайлбал, олон нийтийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, төрийн бус байгууллага, ашгийн төлөө бус хуулийн этгээд гэх мэт эрх зүйн хувьд харилцан ялгаатай нэр томъёог хэрэглэж ирсэн.
- **Төрөл, хэлбэрийн зохицуулалт зөрчилтэй** – Эвлэлдэн нэгдэх эрхийн хүрээнд ИНБ нь өөрийн төрөл, хэлбэрийг чөлөөтэй сонгох эрхтэй ба төрөл болон хэлбэрт тавигдах зохисгүй хязгаарлалт нь эвлэлдэн нэгдэх эрхийн хязгаарлалтад тооцогддог. Гэвч нэр томъёоны харилцан ялгаатай, зөрүүтэй байдлаас үүдэн ТББ төрөл, хэлбэр түүний бүртгэлтэй холбоотой зөрчил, маргаан үүсч байна. Түүнчлэн бүртгэлгүй холбоо, ИНБ-ын албан бус хэлбэрүүдийн зохицуулалт хуульд тусгагдаагүйгээс иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх зөрчигдөх бодит эрсдэл байна.

<sup>3</sup> Д. Тэгшбаяр. (2026). Төрийн бус байгууллагын тухайн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан.

- **Төрийн бус байгууллагын татвар, дэмжлэгийн орчин** – Иргэний нийгмийг бодитоор дэмжих үндсэн хөшүүрэг нь ээлтэй татварын орчин гэж үздэг. 2021 оны судалгаанд ИНБ-ууд өнөөгийн татварын орчин, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн бодлогыг 2,34 буюу хангалтгүй гэж дүгнэсэн. Татварын орчинд иргэн ААН-ийн ТББ-д өгч буй хандивыг татвараас чөлөөлөх, ТББ-ын нийтэд тустай үйл ажиллагаанд татварын хөнгөлөлт үзүүлэх нь зүйтэй гэсэн санал, санаачилга хөндөгддөг.

ТББ-ыг дэмжих хамгийн таатай орчин болон нөөц нь олон нийт, тэдний бүрдүүлж буй нийгмийн капитал байна. Иймд, ТББ-ын хөгжлийг дэмжихэд төр нэн тэргүүнд иргэд, ААНБ-аас ТББ-д хандив, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллахад хөшүүрэг болох ээлтэй орчныг бий болгох нь төрийн дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлэхээс ч илүү үр дүнтэй юм. Учир нь олон улс орны жишгээр төрийн санхүүгийн болон бусад дэмжлэг нь төрөөс хараат байдлыг нэмэгдүүлэх эрсдэл үүсгэхээс гадна уг дэмжлэгийн тогтолцоог хүнд суртал, авлигаас ангид байлгахад багагүй хүчин чармайлт шаарддаг. Иргэд, ААНБ, олон нийтийн хандив, дэмжлэгийг нэмэгдүүлэх гол хөшүүрэг нь татварын зохицуулалтаар шийдэгдэнэ. Түүнчлэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын таатай орчин нь ТББ-уудад учрах санхүүгийн дарамтыг бууруулж, чадавхаа бэхжүүлэх боломжийг бий болгоно.

- **ТББ-ын эрхийг хамгаалах** –ТББ-ууд төрийн албан


хаагч, байгууллагын зүгээс зүй бус дарамт, хяналт, оролцоонд өртөх эрсдэл өндөр байгааг харуулдаг<sup>4</sup>. Хэдийгээр Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль батлагдан хэрэгжиж байгаа ч ТББ-уудын эрхийг хамгаалах, хангуулах явдал дутагдалтай хэвээр байна. Иймд иргэний эвлэлдэн нэгдэх эрх, ИНБ-ын хууль ёсны эрхийг зүй бус төрийн хяналт, оролцоо, дарамтаас ангид байлгах хамгааллын тогтолцоог эрх зүйн орчинд бэхжүүлж өгөх шаардлагатай.

Иргэний орон зайн бодлого, эрх зүйн орчныг сайжруулахад **нэгдүгээрт**, иргэний нийгмийн тухай ойлголт, төрөөс баримтлах, харилцах, хамтрах зарчмыг тодорхойлсон үзэл баримтлал, бодлогын баримт бичгийг батлах замаар нэгдмэл ойлголтыг бүх шатанд бүрдүүлэх шаардлагатай, **хоёрдугаарт**, одоо байгаа эрх зүйн орчныг дээрх болон бусад практик хэрэгцээнд үндэслэн шинэчлэн сайжруулах хэрэгцээтэй байна.

Иргэний нийгэмд тулгамдаж буй дараагийн суурь асуудал нь иргэдийн оролцоо юм. Иргэдийн сайн дурын үйл ажиллагааны талбар болохын хувьд иргэний орон зайн амин сүнс нь иргэний оролцоо билээ. Гэвч иргэдийн оролцоо сүүлийн 20 жилийн хугацаанд тууштай буурч байгаа нь иргэний нийгмийн салбарт зайлшгүй анхаарах тулгамдсан асуудал мөн. Тухайлбал ИНБ-д гишүүнчлэлтэй иргэдийн хувьд 2002-2022 онд тав дахин буурсан байна.

<sup>4</sup> О.Саранчулуун, Ц.Батсугар. (2021). Иргэний орон зайн төлөв байдал, түүнийг дэмжих эрх зүйн таатай орчныг бий болгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа. Иргэний Нийгмийн Консорциум. Улаанбаатар.

Дүрс 2 Олон нийтийн байгууллага дахь иргэдийн оролцоо



Эх сурвалж: Азийн барометрын судалгаа

Иргэний оролцоог дэмжих нь хүмүүн төвтэй, тэгш, хүртээмжтэй, нээлттэй иргэний орон зайг бэхжүүлнэ. Түүгээр зогсохгүй, улам бүр хумигдаж буй иргэний орон зайд нийтийн эрх ашгийн төлөө үйл ажиллагаа явуулахад ИНБ-ууд өөрсдийн нийгмийн капитал, үнэт зүйлд тулгуурласаар ирсэн. Үргэлж нөөц, санхүүжилтийн дутагдалтай тулгарч байдаг иргэний нийгэмд иргэдийн сайн дурын оролцоо нэн чухал нөөц юм. Иймд дараах асуудлуудад нэн тэргүүн анхаарал хандуулахыг зөвлөж байна. **Нэгдүгээрт**, ИНБ-д гишүүнээр элсэх, гишүүнчлэлийн татвар төлөх, иргэд олон нийтийн хандив тусламж нь иргэний нийгмийн салбар дахь хараат бус санхүүжилтэд чухал нөлөөтэй. 2021 оны судалгаанд хамрагдсан ТББ-ын 39,4% гишүүнчлэлийн татвараас, 33,2% нь иргэд ААН-ийн хандиваас орлого олсон нь иргэдийн оролцоо, дэмжлэгийн санхүүгийн ач холбогдлыг тодотгож байна. **Хоёрдугаарт**, иргэний нийгмийн салбар нь иргэдийн сайн дурын оролцоонд тулгуурлан үйл ажиллагаагаа явуулж байна. Хэдийгээр ТББ-ууд хүний нөөцийн хомсдолтой байдаг ч 2021 оны судалгаанд хамрагдсан бараг бүх ТББ сайн дурын ажилтантай байсан. Өөрөөр хэлбэл, иргэдийн сайн дурын ажил нь ИНБ-уудын сөрөн тэсвэрлэх чадвар, тогтвортой үйл ажиллагаа

явуулахад чухал капитал юм. Иймд цаашид иргэдийн итгэл, оролцоог нэмэгдүүлэх нь иргэний орон зайг тэлээд зогсохгүй, иргэний нийгмийн чадавхийг бэхжүүлэхэд нэн чухал. Үүний тулд, иргэний нийгмийн салбар иргэдийн эрх ашгийг чухалчилсан, хариуцлагатай, ил тод, нээлттэй, хүртээмжтэй үйл ажиллагааны зарчмыг тууштай баримтлан ажиллах шаардлагатай.

Ардчилал, засаглалын уналт, технологийн шинэчлэл, геополитикийн нөхцөл байдал, түүнтэй уялдсан олон улсын хөгжлийн санхүүжилт буурах зэрэг өдгөө өрнөж буй үйл явдлууд болон чиг хандлагын нөлөөгөөр иргэний орон зайн практик бэрхшээлүүд гүнзгийрсээр байна. Улам бүр хумигдаж буй иргэний орон зай, санхүүжилтийн хүртээмжийн хумигдал зэрэг нь нөөцийн хомсдол, чадавхийн сул байдлыг улам бүр гүнзгийрүүлэх эрсдэл дагуулж байна. Иргэний нийгмийн салбарын засаглал, хариуцлагын тогтолцоо сул, хамтын ажиллагаа бүрэлдээгүй, иргэний оролцоо, дэмжлэг буурч байгаа нь иргэний нийгмийн салбарын эмзэг байдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Улмаар өдгөө идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын үйл ажиллагааны тогтвортой байдал суларч, үйл ажиллагаа нь тасалдах, цаашлаад бүрэн зогсох

эрсдэл нэмэгдэх төлөвтэй байна.

### Иргэний нийгмийн чуулган, ач холбогдол

Иргэний орон зайн энэ эгзэгтэй мөчид Иргэний нийгмийн чуулган нь иргэний нийгмийн салбарт тулгамдаж буй асуудал, бэрхшээл, тэдгээрийг даван туулах арга замыг хэлэлцэх, эв санааны нэгдэл, хамтын ажиллагаа, хариуцлагыг бэхжүүлэх чухал талбар болж байна.

Монголын ИНБ-ууд нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудал, салбар бүр дэх бодлого, шийдвэрт иргэдийн эрх ашгийг тусгахын төлөө идэвхитэй, тууштай үйл ажиллагаа явуулдаг. Гэвч өөрсдийн салбарт тулгамдаж буй асуудал, бодлого, эрх зүйн шинэчлэлтийг хэлэлцэх боломж хомс байсаар ирсэн. 2022 оны 8 дугаар сард зохион байгуулсан “Иргэний орон зайг хамгаалах нь”<sup>5</sup> сэдэвт чуулганаас хойш иргэний нийгмийн салбарын асуудлаар салбарын томоохон хэлэлцүүлэг завсардаад байсан билээ.

Харин энэхүү орон зайг нөхөж 2025 онд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн санаачилгаар ЛЭОС ТББ-тай хамтран иргэний нийгмийн өдөр (01.31)-ийг тохиолдуулан “Өөрчлөлтийн дуу хоолой” иргэний нийгмийн форумыг 50 гаруй байгууллагын 73 төлөөлөгчдийг хамруулан зохион байгуулжээ. Энэхүү

<sup>5</sup> *Иргэний нийгмийн консорциум саначлан иргэний нийгмийн тулгамдсан асуудал, Холбооны эрх зүйн байдлын болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслүүдийн эрсдэл, зэрэг цаг үеийн асуудлыг хэлэлцэх зорилгоор Олон Улсын Бүгд Найрамдахчуудын хүрээлэнтэй хамтран “Иргэний орон зайг хамгаалах нь” сэдэвт чуулганыг төр, иргэний нийгэм, эрдэм шинжигээний салбарын төлөөлүүдийг хамруулан зохион байгуулсан.*

чуулганаар иргэний орон зайн болон иргэний нийгмийн салбарын хөгжлийн тулгамдсан асуудлыг хэлэлцсэнээс гадна иргэний нийгмийн хариуцлагатай байдлын зарчмуудыг танилцуулан баталгаажуулсныг онцолж байна. Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: иргэний нийгмийн санаачилга<sup>6</sup> нь ИНБ-ууд үйл ажиллагаандаа баримтлах 9 зарчим бүхий өөрийн удирдлагын хариуцлагын механизмыг дэмжих хөшүүрэг болжээ. Иргэний нийгмийн байгууллагад зориулсан цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлага<sup>7</sup> нь мөн иргэний нийгмийн өөрийн удирдлагын тогтолцооны нэг чухал хэрэглэгдэхүүн болсон байна. Энэ мэтчилэн иргэний нийгмийн эрх зүйн орчинг бэхжүүлэх талаар хэлэлцэхийн сацуу иргэний нийгмийн байгууллагууд өөрсдийн эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн харилцаагаа сайжруулахын төлөө хүчин чармайлт гаргаж, олон янзын санал санаачилга өрнөж буй онцлон тэмдэглэх нь зүйтэй.

2026 онд Хэвлэл мэдээллийн зөвлөл, Монголын залуучуудын эвсэл ТББ хамтран “Хөгжлийн төлөөх түншлэл: Төр, иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх” сэдэв чуулганыг иргэний нийгмийн өдөр (01.30)-ийг тохиолдуулан зохион байгууллаа. Тус чуулганд Улаанбаатар хот төдийгүй орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагын төлөөлөл 100 орчим оролцогч хамрагдав. Иргэний нийгмийн салбар ийм олноороо, тэр тусмаа орон нутаг, салбар бүрийн оролцоог ханган чуулж

<sup>6</sup> *Эх сурвалж: V08\_ACS\_MN*

<sup>7</sup> *Эх сурвалж: resource4.*

*sodonsolution.org/mediacouncil/File/2026/02/10/liz83nkh63c19cno/Цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлага.pdf*

өөрсөддөө тулгарч буй бэрхшээл боломж, иргэний орон зай, салбарын хөгжлийн асуудлыг хэлэлцэх завшаан тэр бүр тохиодоггүй. Иргэний орон зай хумигдаж, иргэний суурь эрх чөлөө хязгаарлагдаж, иргэний нийгмийн салбар олон шинэ сорилттой тулгарч буй энэ үед энэ мэт хэлэлцүүлэг, оролцооны талбар бий болгож буй нь чуулганы ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг тодотгож байна. Улмаар 2008 оноос тэмдэглэж эхэлсэн Иргэний нийгмийн өдөр /1-р сарын 31/-ийг тохиолдуулан уламжлал болгон зохион байгуулж буйг онцлохын сацуу цаашид тасралтгүй хадгалж үлдэхийг оролцогч талуудад сануулж байна.

Энэ удаагийн Иргэний нийгмийн чуулганы гол сэдэв нь иргэний нийгмийн хариуцлага, хамтын ажиллагаа, хууль эрх зүйн орчны шинэчлэл, төр-иргэний нийгмийн түншлэл зэрэг өргөн хүрээний цогц асуудлууд байв. ТББ-ын тухай хууль батлагдсаны 30 жилийн ой тохиож буй энэ цаг үед иргэний нийгмийн бодлого, эрх зүйн орчин, иргэний орон зайн хөгжлийн түвшин хийгээд бусад тулгамдсан асуудлуудаа хамтдаа хэлэлцэж буйг сайшаан тэмдэглэе.

Түүнчлэн, 2025 онд иргэний нийгмийн хариуцлагын зарчимд 18 ТББ нэгдэж байгууллагынхаа дотоод засаглал, ил тод байдал, эгэх хариуцлага, олон нийтийн харилцаа холбоогоо бэхжүүлэхэд анхааран ажиллаж буй. Тэдгээрийн зарим төлөөлөл өөрсдийн сайн туршлага, үйл ажиллагаа, ололт сургамжаа хуваалцсан нь иргэний нийгмийн чуулганы уялдаа холбоо, залгамж чанарыг харууллаа.

Энэ удаагийн чуулганд оролцогчдоос 10 ТББ иргэний нийгмийн хариуцлагын зарчимд шинээр нэгдсэн нь төрийн бус байгууллагууд эгэх хариуцлагатай, тогтвортой

хөгжлийн төлөө тууштай хүчин чармайлт гаргаж буйгаа илтгэсэн сайн жишиг болж байна.

Энэ удаагийн чуулганаар онцлон хөндсөн, хэлэлцсэн, шийдэл хайсан сэдэв нь иргэний нийгмийн бодлого, эрх зүйн орчин, өөрийн удирдлагын механизм байв. 2021 онд өргөн баригдсаны дараа иргэний нийгмийн тууштай эсэргүүцлийн үр дүнд буцаагдсан Холбооны эрх зүйн байдлын тухай болон Сангийн эрх зүйн байдлын тухай хуулиуд нь иргэний орон зай, эвлэлдэн нэгдэх эрх, иргэний нийгмийн салбарын хөгжилд сөрөг үр дагавар авчрах эрсдэл дагуулж байсан. Гэвч иргэний нийгмийн байгууллага зөвхөн төрөөс ээлтэй бодлого, хууль боловсруулахыг хүлээхээс илүүтэй олон улсын сайн туршлага, хүний эрх, ардчилал, сайн засаглалын зарчим, Үндсэн хуулийн нийтлэг үнэт зүйлд тулгуурласан бодлогыг санаачлан боловсруулж, шийдвэр гаргагчдад уламжлахаар ажиллаж буйг сайшаан тэмдэглэх нь зүйтэй. Тодруулбал, Иргэний нийгмийн консорциумаас боловсруулсан “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого” баримт бичгийн төслийг энэ удаагийн чуулганаар танилцуулан хэлэлцүүлсэн юм.

Иргэний нийгмийн энэ мэт нэгдмэл бөгөөд тууштай хүчин чармайлтыг бодит үр дүнд хүргэхэд төрийн идэвхитэй, нээлттэй, хариуцлагатай хамтын ажиллагаа хамгаас чухал байна. Төр-иргэний нийгмийн шударга, хариуцлагатай түншлэлийг хөгжүүлэх суурь алхам нь төрөөс иргэний чөлөөт орон зайг хамгаалах, бэхжүүлэх хууль эрх зүйн болон бодлогын орчныг бүрдүүлэх явдал юм.

### Иргэний орон зайн эрх зүйн орчныг сайжруулах нь

ТББ-ын тухай хуулийг шинэчлэх цаг үеийн шаардлага бий болсон

гэдэгт иргэний нийгмийн салбарынхан санал нэгддэг. Чуулганд судлаач Д.Тэгшбаяр ТББ-ын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнг танилцуулсан нь ТББ-ын хуулийг шинэчлэх практик хэрэгцээ шаардлагыг тодорхой харуулав. Тус үнэлгээгээр 1997 оны ТББ-ын тухай хууль тодорхой хугацаанд үүргээ гүйцэтгэсэн ч нийт 11 чиглэлээр үнэлэхэд хоёр чиглэлд зорилгод хүрсэн боловч есөн чиглэлд практикт зөрчилтэй, нийгмийн хөгжил, хувьсалд нийцүүлж хуульд өөрчлөлт оруулах хэрэгцээ үүссэн байгааг тодотгосон. Иргэний нийгмийн салбарынхан ч 1997 оны ТББ-ын тухай хууль чөлөөт иргэний нийгмийг цогцлоход чухал үүрэг гүйцэтгэсэн. Уг хууль батлагдсанаар Үндсэн хуулиар баталгаажсан иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрэлдэж, эвлэлдэн нэгдэх эрхийн баталгаа хангагдсан.<sup>8</sup> Хэдий тийм ч ТББ-ын тухай хуулийг өдгөө шинэчлэн сайжруулах шаардлагатай болсныг цохон тэмдэглэж байв.

Гэвч ТББ-ын тухай хуулийг шинэчлэхээс урьтаж иргэний нийгмийн талаарх үзэл баримтлал, үнэт зүйл, зарчим зэргийг тодорхойлсон нэгдсэн ойлголт, хандлагыг төр, иргэний нийгэм болон бусад салбарт нэгэн цогц байдлаар төлөвшүүлэх шаардлагатай байна. Энэ нь иргэний нийгмийн талаарх нэр томъёоны болон ойлголтын зөрүүг арилгахын сацуу төр-иргэний нийгмийн хамтын ажиллагааны үндсэн зарчмуудыг тогтох, иргэний нийгмийн хөгжлийн үзэл санааг багатгах, улмаар аливаа хууль, эрх зүйн баримт бичгийг нэгэн үзэл санаагаар батлан

<sup>8</sup> Хууль зүйн үндэсний хүрээлэн, (2018). “Төрийн бус байгууллагын тухай хууль”, *Харьцуулсан судалгаа*.

хэрэгжүүлэх суурь болно.

Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын төслийг 2012 оноос иргэний нийгмийнхэн санаачлан манлайлан ажиллаж, улмаар 2021 онд дахин сайжруулж, 2025 оноос хэд хэдэн удаа хэлэлцүүлсэн хувилбарыг судлаач Д.Сүхжаргалмаа танилцуулан, чуулганаар хэлэлцүүлэв. Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлогын төсөл нь бодлого, эрх зүйн орчныг бэхжүүлэхэд иргэний нийгмийн манлайллыг илтгэх төдийгүй иргэний орон зайн талаар нэгдмэл үзэл санаа, үнэт зүйлийг бэхжүүлэх тууштай оролдлого юм. Төр-иргэний нийгмийн хариуцлагатай, эрх тэгш түншлэлийг бэхжүүлэхэд нэгдмэл үзэл баримтлал, үнэт зүйл, зарчим зайлшгүй юм. Тиймээс энэхүү баримт бичгийг батлах нь төр-иргэний нийгмийн түншлэлийг бэхжүүлэх суурь алхам болно. Чуулганы мөрөөр бодлогын баримт бичгийн төслийг батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхэд 2026 оны 2 дугаар сарын 11-нд өргөн барьсан нь иргэний нийгмийн эв санааны нэгдлийг илэрхийлсэн түүхэн алхам боллоо.

### Салбарын хариуцлагатай хөгжил

2021 оноос идэвхжсэн иргэний нийгэмд хамаарах хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийн үеэр төрийн бус байгууллагуудыг цэгцлэх тухай яриа эрчтэй өрнөж эхлэв. Бодлого боловсруулагч, хууль санаачлагчдын зүгээс төрийн бус байгууллагын тоо хэт өссөн, нэгдмэл бус, үйл ажиллагаагаа тогтвортой явуулдаггүй, тайлагналт, хяналтын тогтолцоо сул, ашгийн бус этгээд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж байна, улмаар мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон байж болзошгүй гэх

зэрэг олон шалтгааныг дурдсан. Эдгээр нь нэг талаас иргэний нийгмийн нэр хүнд, итгэл үнэмшил, тогтвортой хөгжилд сөрөг үр дагавруудыг дагуулсан. Гэвч нөгөө талаас иргэний нийгмийн салбар өөрсдийгөө эргэж харах, орчиноо сайжруулах боломж байв.

Өдгөө 30 гаруй мянган төрийн бус байгууллага албан ёсоор бүртгэлтэй байна.<sup>9</sup> Эдгээр нь нийгмийн олон ялгаатай бүлэг, салбарын эрх ашиг, дуу хоолой, хэрэгцээ шаардлагаас үүдэн бий болсон. Мэдээж төрөл, хэлбэр, бүтэц зохион байгуулалт, зорилго чиглэлээрээ ялгаатай байгууллагуудаас иргэний нийгмийн салбар бүрддэг. Эвлэлдэн нэгдэх эрхийн нэг гол шинж нь ИНБ-ууд өөрсдийн төрөл, хэлбэр, бүтэц зохион байгуулалтыг чөлөөтэй сонгох, тодорхойлох эрх юм. Иймд иргэний орон зайд ээлтэй хууль, эрх зүйн зохицуулалтад ИНБ-ын төрөл, хэлбэрийг хуулиар хязгаарлах, дотоод зохион байгуулалт, бүтцийг хэт нарийвчлан хуульчлахыг сайшаадаггүй. Үүгээр зогсохгүй, иргэний орон зайн эрх зүйн зохицуулалт нь гагц бүртгэгдсэн хуулийн этгээд бус, бүртгэгдээгүй сайн дурын иргэдийн нэгдэл холбоог ч хамруулан тусгаснаар эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулдаг. Энэ утгаараа ИНБ-ын төрөл, хэлбэр, бүтцийн олон янз байдал нь эвлэлдэн нэгдэх эрх хэрэгжиж байгаагийн илрэл юм. Иймд “иргэний нийгмийг цэгцлэх”, ТББ олширсон, үйл ажиллагаа явуулдаггүй гэх мэтээр шүүмжлэн, хязгаарлахыг урьтал болгохоос илүүтэй өдгөө

<sup>9</sup> Эх сурвалж: *Бизнес регистрийн сан, УСХ, БИЗНЕС РЕГИСТРИЙН САНД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТОО, үйл ажиллагаа эрхлэлтийн байдал, хариуцлагын хэлбэр, жилээр by Үйл ажиллагааны эрхлэлтийн байдал, Хариуцлагын хэлбэр and Он. Рхweb*

төлөвшин тогтож буй иргэний нийгмийн олон янз байдлыг хамгаалах, бэхжүүлэх замаар салбарын тулгамдсан асуудлыг шийдэж, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь төрийн үүрэг, хариуцлага юм.

Нөгөөтэйгүүр өнөөгийн эрх зүйн орчны хийдэл, зөрчлөөс үүдэн төрийн бус байгууллагаар дамжуулан ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах гэх мэт асуудал гарч буй талаар хууль санаачлагчид шүүмжилдэг<sup>10</sup>. Энэ мэт сөрөг үзэгдэл нь иргэний нийгмийн салбарыг бүхэлд нь харлуулах, иргэний орон зайг хумих зохист шалтгаан биш боловч иргэний нийгмийн талаарх сөрөг мэдээлэл, санаа бодлыг өдөөх, улмаар иргэдийн оролцоо буурах, итгэл, дэмжлэг сулрахад нөлөөлж байна. Иймд, ИНБ-ууд өөрсдөө ил тод байдал, хариуцлага, ёс зүйгээрээ ялгарах шаардлагатай байна.

Монголын иргэний нийгэм цаашид хөгжин бэхжихийн тулд салбарын хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, нийтлэг үнэт зүйл, зарчим, ил тод байдалд суурилсан хөгжлийн чиг хандлагыг тууштай бэхжүүлэх шаардлагатай байна. Салбарын хариуцлагатай хөгжил нь нэг талаас иргэний нийгмийн төлөвшлийг гүнзгийрүүлэх, нөгөө талаас ил тод, хариуцлагатай ажиллаж буй ИНБ-ууд бодитоор ялгарч, олон нийтийн итгэл, дэмжлэгийг бэхжүүлэх ач холбогдолтой. Энэ хүрээнд байгууллагууд дотоод засаглал, тайлагнал, ил тод байдлын механизмаа сайжруулах, олон нийттэй харилцах ёс зүйн нийтлэг зарчмыг баримтлах, сайн дурын үндсэн дээр салбарын хамтын санаачилга, өөрийн удирдлагын механизмыг төлөвшүүлэх

<sup>10</sup> Эх сурвалж: *ХОЛБООНЫ-ЭРХ-ЗҮЙН-БАЙДЛЫН-ТУХАЙ-ХУУЛИЙН-ТӨСӨЛ-ҮЗЭЛ-БАРИМТЛАЛЫН-ТАНИЛЦУУЛГА.pdf*

боломжийг судлах, тогтмол туршлага солилцох замаар чадавх, нөөцөө хөгжүүлэх зэрэг алхамуудыг нэн даруй хийх шаардлагатай байна.

### Хамтын ажиллагаа сөрөн гэсвэрлэх чадавх болох нь

Монголын иргэний нийгэм бүрэлдэн хөгжөөд удаагүй ч олон ялгаатай бүлгийн дуу хоолойг нэгтгэсэн бие даасан салбар болон төлөвшиж байна. Гэвч чадавхийн хувьд иргэний нийгмийн салбар эмзэг бөгөөд хэврэг хэвээр байна. Тухайлбал, хүний нөөцийн хомсдол, санхүүжилтийн хязгаарлагдмал байдал, институцийн төлөвшил сул гэх мэт. Улс төр, эдийн засаг, геополитик болоод технологийн дэвшил, чиг хандлагаас үүдэлтэй шинэ сорилтууд нь иргэний нийгмийн цаашдын хөгжилд онцгой сорилтуудыг авчирч байна.

Ийнхүү иргэний нийгмийн байгууллагууд улам бүр хумигдаж буй хязгаарлагдмал нөөцөөр хэрхэн яаж үр дүнтэй үйл ажиллагаа явуулж тогтвортой хөгжих вэ? Иргэдийн дуу хоолойг төрд хүргэх, хүний эрх, эрх чөлөө, иргэний орон зайг хамгаалах, улмаар төрийн бодлого, үйл ажиллагаанд хяналт тавихын зэрэгцээ өөрсдийн бие даасан байдал, тогтвортой хөгжлийн орчиноо хэрхэн яаж хамгаалах вэ? зэрэг олон сорилт, бэрхшээлтэй өдөр бүр нүүр тулж байна.

Салбарын хэмжээний томоохон сорилтуудтай нүүр тулж, даван туулахад төрийн бус байгууллагуудад эв нэгдэл, нэгдмэл байдал, хамтын ажиллагаа хамгаас чухал. Шийдэл ямар байхаас үл хамааран тэгш оролцоог хангасан хэлэлцүүлэг, яриа хэлэлцээр, хамтын ойлголцол, салбар хоорондын уялдаа холбоог нэмэгдүүлэх нь нэн тэргүүний алхам юм. Иймд нэгдмэл үнэт

зүйл, зарчимд суурилсан иргэний нийгмийн салбарын нягтрал, хамтын ажиллагаа, цаашлаад өөрийн удирдлагын тогтолцоо нь иргэний орон зай, эрх чөлөөг хамгаалах, иргэний нийгмийн байгууллага, зүтгэлтнүүд, хүний эрх хамгаалагчийн хууль ёсны эрх ашгийг дээдлэх, салбарын хамтын хариуцлагыг бэхжүүлэх, мөн сөрөн тэсвэрлэх чадавхийг нэмэгдүүлэх хөшүүрэг болно.

### Чуулганы үр дүн, цаашдын алхам

Дүгнэвэл, иргэний нийгмийн чуулган иргэний орон зайг хамгаалах, иргэний нийгмийн хариуцлагыг бэхжүүлэх, салбарын хөгжлийн сорилтуудыг хэлэлцэх нэн чухал төдийгүй нэн ховор талбар байв. Иргэний суурь эрх чөлөө хязгаарлагдаж, иргэний орон зай хумигдаж, иргэний нийгмийн салбарт сорилтууд нэмэгдэж буй энэ цаг үед чуулганы ач холбогдол улам бүр өндөр байлаа. Оролцсон төрийн бус байгууллагууд чуулж өөрсдийн сөрөн тэсвэрлэх чадварын, хариуцлагатай хөгжлийн туршлагаа хуваалцсан нь иргэний нийгмийн хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлж байна.

Иргэний нийгмийн байгууллагууд нээлттэй, ил тод, хариуцлагатай, тэгш хүртээмжтэй, оролцоотой, тогтвортой иргэний орон зайг төлөвшүүлэхийг зорьж байна. Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: иргэний нийгмийн санаачилгын зарчимд олон байгууллагууд нэгдэн орж буй нь үүний тод илэрхийлэл юм.

Чуулганы шууд үр дүнд “Төрөөс иргэний нийгмийн талаар баримтлах бодлого”-ын төслийг хэлэлцэж, улмаар ерөнхийлөгчид өргөн барьсан нь ээлтэй бодлого, эрх зүйн орчныг цогцлоох чиглэлд хийж буй дорвитой алхам юм.

Иргэний нийгмийн чуулганыг цаашид тогтмолжуулж, иргэний орон зайн тулгамдсан асуудал, салбарын хөгжлийн загварыг хэлэлцэх, хамтын ажиллагааг хөгжүүлэх талбар болгон өргөжүүлэх, оролцоо, хамрах хүрээг нэмэгдүүлэх нь иргэний нийгмийн хөгжил, сөрөн тэсвэрлэх чадавхийг бэхжүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэнэ.

Цаашид дараагийн чуулганаар төр-иргэний нийгмийн түншлэлийн бодит механизм, иргэний орон зайн эрх зүйн шинэчлэл, татварын таатай орчин, орон нутгийн ИНБ-уудын чадавх, дижитал орчин дахь иргэний оролцоо, салбарын өөрийн удирдлагын механизмын хэрэгжилт зэрэг сэдвийг тусгайлан хэлэлцэх, шийдэл дэвшүүлэх, олон талт зөвшилцлийг бүрдүүлэх нь чухал.

Мөн энэ удаагийн чуулганы мөрөөр ИНБ-уудын хариуцлагатай засаглал, чадавх бэхжүүлэх ажлыг өргөжүүлэн үргэжлүүлэх шаардлагатай. Чуулганы үеэр ТББ-ууд хариуцлагатай, тогтвортой дотоод засаглалыг бэхүүлэх сонирхол, хэрэгцээ байгаа нь тод ажиглагдсан. Түүнчлэн, салбарын өөрийн удирдлагын талаар ярих цаг болсон нь хурлын уур амьсгалаас мэдрэгдэж байлаа. Иймд салбарын өөрийн удирдлагын тогтолцоо, түүний зарчим, үнэт зүйл, хэрэгжүүлэх арга замын талаар дорвитой судалгаа, хэлэлцүүлгийг үргэлжлүүлбэл зохистой. Мөн иргэний орон зайн эрх зүйн ээлтэй орчныг бүрдүүлэх чиглэлд олон нийт, бодлого гаргагчдад чиглэсэн нөлөөллийн ажлыг ИНБ-ууд хамтран хэрэгжүүлэх нь чухал.

Чуулганаар хөндөгдсөн эдгээр олон чухал сэдвийг ажил хэрэг болгохын тулд ИНБ-ууд зохион байгуулалтад орж тууштай

ажиллах нь чухал бөгөөд үүнд хөгжлийн түншүүд болон бусад оролцогч талуудыг дэмжлэг зайлшгүй хэрэгцээтэй билээ.

\*\*\*\*\*

*Чуулганы ажиглалтын тайланг Хэвлэл мэдээллийн зөвлөл, Дойче Велле Академийн хамтран хэрэгжүүлж буй “Өөрчлөлтийн дуу хоолой: ИНБ-ууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтыг сайжруулахын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийн хүрээнд бэлтгэж нийтлүүлэв. Энэхүү ажиглалтын тайлан нь судлаачийн хөндлөнгийн дүгнэлт, санал зөвлөмж бөгөөд төсөл санхүүжүүлэгч Европын Холбооны албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй болно.*

## ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг Европын Холбооны дэмжлэгтэйгээр Хэвлэл мэдээллийн зөвлөл, Дойче Велле Академи хамтран хэрэгжүүлж байна.

### Санхүүжүүлэгч:

Европын Холбоо

### Хэрэгжүүлэгч:

Монголын

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, ХБНГУ-ын Дойче Велле Академи

**Хэрэгжих хугацаа:** 2023-2026 он

### Төслийн зорилго:

Иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулахад чиглэнэ.

**ЗОРИЛТ 1.** ИНБ-уудын засаглал, цахим орчинд ажил хэргээ эрхлэх, үйл ажиллагаа явуулах чадавх сайжирч, “Хариуцлагатай иргэний нийгэм”-ийн удирдамжийг бий болгосон байна.

**ЗОРИЛТ 2.** Төр, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн иргэдийн оролцоог дэмжих эрх зүйн болон бодлогын таатай орчныг бүрдүүлэх талаар харилцан ойлголцлоо нэмэгдүүлнэ.

**ЗОРИЛТ 3.** ИНБ, хэвлэл мэдээлэл хамтран бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулахдаа залуучууд, нийгмийн бусад бүлгийг идэвхтэй оролцуулах цахим харилцааны шинэ хэлбэрийг дэмжинэ.

### Зорилтот бүлгүүд

● **ИНБ:** Иргэний нийгмийн салбарын хот, хөдөөгийн нийт 500 ажилтан – үүний 50% нь залуучуудтай ажилладаг

● **Залуучууд:** 16–35 насны 800 залуу – 50% нь эмэгтэй.

● **Хэвлэл мэдээлэл:** Хот, хөдөөгийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг 500 ажилтан (сэтгүүлч, редактор гэх мэт) – 50% нь эмэгтэй.

● **Төрийн төлөөлөгчид:** Хот, хөдөөгийн 100 улс төрийн болон төрийн албан хаагч – иргэний нийгмийн асуудалд сонирхолтой, өөрчлөлт авчрах чадамжтай бүлэг.

### Хэвлэл Мэдээллийн Зөвлөл

(ХМЗ) нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд анхлан байгуулагдаж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд даруй 10 дахь жилдээ орж буй НҮТББ билээ. Энэ хугацаанд Хэвлэл Мэдээллийн Зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын хариуцлагыг сайжруулах, сэтгүүл зүйн ёс зүй болон мэргэжлийн стандартыг хөгжүүлэх зэрэг үйл ажиллагааны үндсэн чиглэлийнхээ хүрээнд олон нийтээс ирүүлсэн 600 гаруй гомдлыг хүлээн авч, хэлэлцэн шийдвэрлээд байна. Улмаар хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад өөрсдийн бий болгосон ёс зүйн зарчмаа дагаж мөрддөг, салбарын өөрийн зохицуулалтын механизмыг амжилттай бий болгоод байна.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтыг хөгжүүлэн

бэхжүүлж буй туршлага болон хэвлэл мэдээлэл - төр - иргэний нийгмийн хөгжлийн төлөөх хамтын түншлэл, харилцаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанууд нь хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн эгэх хариуцлагыг хөндөх “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг хэрэгжүүлэх үндэс суурь болсон юм.

Гурван жилийн хугацаатай хэрэгжих уг төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, ХБНГУ-ын Дойче Велле Академи хамтран хэрэгжүүлэх бөгөөд иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулах юм.

# МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ 2026

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл

## ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ЗУРГААС



# МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ 2026

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл

